



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 01 сарын 25 өдөр

Дугаар

1/03

Номгон

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах
чиглэлээр 2026 онд хэрэгжүүлэх арга
хэмжээний төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.1.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 9/58 дугаар “Аймгийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөг батлах тухай” тогтоолын 90 дэх, Аймгийн Засаг даргын 2026 оны А/25 дугаар “Төсөл хөтөлбөр, бодлого, стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээнд хөрөнгө зарцуулах тухай” захирамжийн 4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр 2026 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардалд 2,000,000 (Хоёр сая) төгрөгийг хөгжлийн төлөвлөгөөний арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (С.Байгалмаа)-д зөвшөөрсүгэй.

3.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав)-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (П.Отгонбаяр)-д даалгасугай.

ДАРГА



Э.ЭНХБАТ

Аймгийн Засаг даргын 2026 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 423 дугаар захирамжийн хавсралт

ХЭРЭГЛЭГЧИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ ЧИГЛЭЛЭЭР 2026 ОНД
ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зохион байгуулах ажил, арга хэмжээ	Төсөв сая,төг	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа /I-IV улирал/	Хариуцах албан хаагч
1	2	3	4	5	6	7	8
Зорилт 1. “Шадар сайдтай хамтран ажиллах гэрээнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангах” ажлын хүрээнд							
1	Шадар сайдын гэрээний хэрэгжилтийг ханган ажиллах	-	Гэрээний хэрэгжилтийн хувь	100%	100%	2026.01.05 2026.12.25	Монополын эсрэг газрын Улсын байцаагч Б.Анухатан
2	Монополын эсрэг газраас ирүүлсэн албан бичиг, үүрэг чиглэлийг хэрэгжүүлэн ажиллах	-	Ажил арга хэмжээ, үүрэг чиглэлийн хэрэгжилтийн хувиар	100%	100%	2026.01.05 2026.12.25	Монополын эсрэг газрын Улсын байцаагч Б.Анухатан
3	Олон Улсын хэрэглэгчийн өдөр буюу 3 дугаар сарын 15-ны өдрийг батлагдсан удирдамжийн дагуу аян зохион байгуулах	-	Аяны тоо	1	1	2026.02.05 2026.03.25	Монополын эсрэг газрын Улсын байцаагч Б.Анухатан
4	Иргэд, аж ахуй нэгж байгууллагаас ирүүлсэн Хэрэглэгчийн эрх ашиг сонирхол зөрчигдсөн тухай гомдол санал хүсэлтийг шийдвэрлэх	-	Гомдол санал хүсэлтийг шийдвэрлэлтийн хувь	100%	100%	2026.01.05 2026.12.25	Монополын эсрэг газрын Улсын байцаагч Б.Анухатан
5	Гомдлын дагуу хяналт шалгалтыг тухай бүр зохион байгуулах	-	Хяналт шалгалтын тоо	3	Тухай бүр	2026.01.05 2026.12.25	Монополын эсрэг газрын Улсын байцаагч Б.Анухатан
6	Гол нэрийн болон Өргөн хэрэглээний хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн		Судалгааны тоо	4	4	2026.01.05 2026.12.25	Монополын эсрэг газрын Улсын байцаагч Б.Анухатан

1	2	3	4	5	6	7	8
	судалгааг улирал бүр авч нэгтгэн МЭГ-т хүргүүлэх						
7	Бараа бүтээгдэхүүний зохиомол хомсдол, үнийн хөөргөдлийн эсрэг аж ахуй эрхлэгчдэд зөвлөмж хүргүүлэх	-	Зөвлөмжийн тоо	1	2	2026.01.05 2026.12.25	Монополын эсрэг газрын Улсын байцаагч Б.Анухатан
Зорилт 2. Хэрэглэгчийг соён гэгээрүүлэх, мэдлэг боловсрол олгох							
8	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, иргэд олон нийтэд чиглэсэн олон талт арга хэмжээ зохион байгуулах	-	Сургалтын тоо	4	Эхний хагас жил 2 Сүүлийн хагас жил -2	2026.01.05 2026.12.25	Х Монополын эсрэг газрын Улсын байцаагч Б.Анухатан Хэрэглэгчийн эрхийг хамгаалах нийгэмлэг
9	Аж ахуй эрхлэгч, хэрэглэгчдийг соён гэгээрүүлэх, нөлөөллийн ажлыг зохион байгуулах	-	Нөлөөллийн ажлын тоо	1	2	2026.01.05 2026.12.25	Монополын эсрэг газрын Улсын байцаагч Б.Анухатан
Зорилт 3. Хэрэглэгчид хүрч байгаа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний стандарт, чанар, аюулгүй байдлын түвшинд хяналт тавих							
10	Аймгийн төвийн Хүнсний үйлдвэрүүдэд бараа бүтээгдэхүүний хаяг шошгын мэдээлэл, бүтээгдэхүүний хадгалалт, хамгаалалт, эрүүл ахуй стандартад Хүнсний тухай хууль, хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль болон бусад хуульд заасан эрх үүргийн хүрээнд хяналт, шалгалт хийж зөвлөмж өгөх	-	Хяналт шалгалтын тоо Зөвлөмжийн тоо	3 -4	Эхний хагас жил-3 Сүүлийн хагас жил -2	2026.01.05 2026.12.25	Монополын эсрэг газрын Улсын байцаагч Б.Анухатан
11	Цаг үеийн шинж чанартай хяналт шалгалтууд тухай бүр зохион байгуулах /Цагаан сар, Өвөлжилтийн нөхцөл байдал, Мах, гурил, өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний үнийн талаарх хяналт шалгалт/	-	Цаг үеийн шинж чанартай хяналт шалгалтууд тухай бүр зохион байгуулж зөрчлийг арилгуулж ажилласан байна.	3	Эхний хагас жил 50% Сүүлийн хагас жил - 50%	2025.01.10 2025.12.25	Хэрэглэгчийн эрхийг хамгаалах Улсын байцаагч Б.Анухатан



حسین مصطفیٰ علی
حسین مصطفیٰ علی

১০০০	১০০০	১০০০
------	------	------

$\frac{z}{0 \mid n}$

विषय

مكتبة دار الكتب
الاسلامية
القاهرة


[illegible][illegible]

.. **എന്താണ് ഈ പ്രശ്നം?**

[illegible][illegible]

۹...در بعضی از نسخه‌های خطی، عبارت «در بعضی از نسخه‌های خطی» به جای «در بعضی از نسخه‌های خطی» آمده است.

जिम्मा



செய்தது.

642501785